



**БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 12 сарын 19 өдөр

Дугаар А/453

Улаанбаатар хот

Дүүргийн 19 дүгээр хороо, Цайзаас Саруул тэнгэр-2 хотхоны арын зам дагуух гэрэлтүүлгийн ажлын барьцаа хөрөнгө чөлөөлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3. дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2016 онд 19 дүгээр хороо, Цайзаас Саруул тэнгэр-2 хотхоны арын зам дагуух гэрэлтүүлгийн ажлыг гүйцэтгэсэн “Нексткүүлэр” ХХК-ийн ажлын барьцаа 3 765 072 /гурван сая долоон зуун жаран таван мянга далан хоёр/ төгрөгийг барьцаа хөрөнгийн данснаас чөлөөлөхийг Засаг даргын Тамгын газар /Б.Амартүвшин/-т зөвшөөрсүгэй.

2. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Эдийн засаг хөгжлийн асуудал хариуцсан төслийн удирдагч-Засаг даргын орлогч Д.Уламбаярт үүрэг болгосугай

ЗАСАГ ДАРГЫН  
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Т.БАЯСАХ